

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД М.ЭНХБОЛДЫН ЯПОН УЛСАД ХИЙСЭН АЙЛЧЛАЛД

*С.Дамбадаржаа**

Монгол дахь улс төрийн гол хүчин Монгол Ардын Хувьсгалт Намын шинэ дарга, Монгол Улсын шинэ Ерөнхий сайд Миезгомбын Энхболд тун саяхан Япон улсад албан ёсны айлчлал хийлээ. Түүний толгойлж буй нам 161,3 мянган гишүүдийг эгнээндээ нэгтгэсэн Монгол орны хамгийн нөлөө бүхий улс төрийн хүчин мөн. Ерөнхий сайдын толгойлж буй Эв Нэгдлийн засгийн газрын шинэ танхимд дөрвөн намын дарга, таван намын төлөөлөл багтсан байгаа. Шинэ засгийн газар улс, эх орныхоо хөгжил, цэцэглэл, ард түмнийхээ сайн сайхны төлөө, дэлхийн улс түмэнтэй найрсаг харилцаа, харилцан ашигтай хамтын ажиллагаа явуулахын төлөө байна.

Ерөнхий сайдын анхны гадаад айлчлал Япон улсаас эхлэж байгаа нь утга учиртай. Монгол орны хөгжил цэцэглэлд Япон улс, түүний ард түмний зүгээс үзүүлж буй халуун дотно сэтгэлийн тусламж нэн чухал үүрэг гүйцэтгэж байгаа юм.

Ерөнхий сайдын энэхүү айлчлалтай холбогдуулан уншигч олондоо Япон орны тухай, Монгол-Японы харилцаа, хамтын ажиллагаа тааламжтай сайхан хөгжиж байгаа тухай товч мэдээлэл өгч, хоёр орны харилцааг ойрын ирээдүйд хэрхэн хөгжүүлэх вэ? гэдэг талаар хувийнхаа санаа бодлоо хуваалцахыг зорьж энэ зүйлийг бичиж байна.

Япон орон

Япон нь дэлхийн хуурай газрын 0,3%-г эзэлдэг, 378 мянган хавтгай дөрвөлжин километр газар нутагтай, 127 сая хүн амтай, үндсэн хуульт хаант улс юм. Төрийн тэргүүн нь хаан. Хаан төрийн хэрэг шийддэггүй, бэлэгдлийн шинжтэй. Хууль тогтоох дээд байгууллага парламент нь зөвлөхүүдийн (дээд), төлөөлөгчдийн (доод) хоёр танхимтай. Улс төрийн 20 орчим намтай. Засгийн эрхийг Либерал Ардчилсан нам (ЛАН), Комэй намын эвсэл барьж байна.

Гадаад бодлогын тэргүүлэгч чиглэл нь АНУ-тай тогтоосон холбоотны харилцаагаа бэхжүүлж, бодлого, үйл ажиллагаагаа бүх талаас нь зохицуулахад төвлөрч байна.

Япон улс эдийн засгийн чадавхиараа АНУ-ын дараа 2-рт ордог. Дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүний (GDP) 12,1%-г үйлдвэрлэдэг (АНУ 32,7%). ДНБ-ний хэмжээ нь 4,4 триллион ам.доллар учир 1 хүнд 34,500 ам.доллар ногддог. Гадаад худалдааны эргэлт нь 98

* С.Дамбадаржаа - Монгол-Японы Түншийн Холбоо нийгэмлэгийн дэд ерөнхийлөгч, ахмад элчин сайд

тэрбум ам.доллар. БНХАУ-тай 8,7 тэрбум, АНУ-тай 6,8 тэрбум, Европтой 6,9 тэрбум ам. долларын худалдаа хийдэг.

Японы эдийн засгийн өсөлт 1980-аад оны дунд үеэс саарч, 1990-ээд онд зогсонги байдалд орж, 1998 онд 0,9%, 2002 онд 1,1%-аар буурсан. 2003 оноос сэргэж 2004 онд 1,9%-ийн өсөлт гарсан.

Япон улс хөгжиж буй орнуудад үзүүлдэг тусламжийн хэмжээгээрээ дэлхийд тэргүүн байр эзэлж 1999 онд 15,3 тэрбум ам.доллараар туслаж байсан бол одоо үед тусламжийн хэмжээ буурч жилдээ 8,9 тэрбум ам.долларын тусламж үзүүлж байна. НҮБ-ын төсвийн 19,4%-г (АНУ 22%) бүрдүүлдэг. Японд гадаадын 117,302 оюутан суралцаж буйн 66,3% нь хятад оюутан байна.

Монгол-Японы харилцаа сүүлийн жилүүдэд

Улс төрийн харилцаа. Сүүлийн 5 жилд Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди, УИХ-ын дарга С.Төмөр-Очир, Ерөнхий сайд Н.Энхбаяр, Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун, Ц.Мөнх-Оргил нар Япон улсад албан ёсны айлчлал хийж, мөн хугацаанд УИХ-ын байнгын хороодын 7 дарга, УИХ-ын 30 гаруй гишүүд албан ёсны болон ажлын айлчлал хийсэн, мөн хугацаанд Монголын 11 сайд албан ёсны болон ажлын айлчлалаар Японд очсон, нийслэл хотын дарга ба 4 аймгийн засаг дарга нар мөн айлчлал хийжээ.

Энэ 5 жилийн хугацаанд Японы парламентын 20 гаруй гишүүд Монголд айлчилсан. Гадаад хэргийн сайд Е.Кавагучи, Гадаад хэргийн дэд сайд Ш.Танигава, дэд сайд Т.Яно нар албан ёсны айлчлалаар ирж байв.

Дээрхи хугацаанд Гадаад хэргийн дэд сайд нарын түвшинд хоёр орны харилцаа, олон улсын асуудлаар зөвлөлдөх уулзалт болж Үйлдвэр, худалдааны сайд нарын уулзалт хэлэлцээ явагдсан.

Эдийн засаг, худалдааны харилцаа. Донор орнууд болон олон улсын байгууллагаас 1991 оноос хойш Монголд 1,211 тэрбум ам.долларын тусламж үзүүлсэний 50%-г Япон үзүүлсэн байв. Үүнд, 4-р цахилгаан станцыг шинэчлэн тоноглох, Монголын төмөр замын тоноглолыг сайжруулах, автобусны компаниудын паркийг шинэчлэх, Шивээ-Овоо, Багануурын уурхайнуудад машин механизм нийлүүлэх, нийслэлийн авто замыг сайжруулах, цаг уурын мэдээллийн сүлжээг сайжруулах, УБ хот, Орхон, Дархан-Уул аймгуудад дунд сургуулийн барилга барих, өргөтгөх зэрэгт уг тусламж зориулагджээ.

Зөвхөн 2005 онд буцалтгүй тусламжаар “Мянганы зам”-д 544 сая иен, ерөнхий боловсролын сургуулиудын өргөтгөлд 1,700 сая иен, хүний нөөцийн төсөлд 400 сая иен, нефть бүтээгдэхүүн авахад 300 сая иен, тариачдад урт хугацааны, хөнгөлөлттэй зээлээр 450 трактор

нийлүүлэхэд зориулан эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр 6,6 тэрбум төгрөгийн тусламж үзүүлжээ.

Хөрөнгө оруулалт. 1990 оноос хойш Японы 224 компаниуд Монголд 71,3 сая ам.долларын шууд хөрөнгө оруулалт хийжээ. Компанийн тоо, мөнгөний хэмжээгээр Япон 4-р байр эзэлж байна.

Монгол Улс Японы ажил хэргийхний анхаарлыг татах боллоо. Мицуи, Сумитомо, Мицубиши, Иточу зэрэг Японд төдийгүй дэлхийд нэртэй аварга том компаниуд Оюу толгой, Таван толгой болон бусад орд газруудад хөрөнгө оруулах санал тавьж байна. Японы эдийн засгийн Кейданрен байгууллагын дэд ерөнхийлөгч С.Шибамы, Сумитомо компаний ерөнхийлөгч К.Мияхара, Иточу компаний ерөнхийлөгч К.Нива, Комацу компаний ерөнхийлөгч Н.Хагивара, Нихон Гайши компаний ерөнхийлөгч зэрэг нэрт бизнесменүүд манайд айлчилж хамтын ажиллагааны талаар санал солилцож байв.

Японы фермерүүдийн аварга том холбоо 10 гаруй хүнтэй төлөөлөгчдөө ирүүлж Хэнтий, Дорнод аймгуудын хөдөө аж ахуйн салбарт хамтын ажиллагаа хөгжүүлэхээр ажлаа эхэлж байна.

Худалдаа. Өнөөгийн үед 2 орны худалдааны эргэлт 61 сая ам.доллар, үүнээс манай импорт 57 сая, экспорт 4 сая ам.долларын хэмжээнд байгаа нь өмнөх онуудаас буурсан бөгөөд энэ нь Монголын зэс, алтны экспортын хэмжээ буурсантай холбоотой юм.

Хөгжлийн Албан Ёсны Тусламжийн (ХАЁТ). Японы ХАЁТ-ийн Монголд зориулсан тусгай хөтөлбөр 2004 оны 11-р сард батлагдсан. 1990-ээд оноос шилжилтийн үеийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд ХАЁТ зориулагдаж байсан бол одоо ирээдүйд чиглэсэн хөгжлийн бодлого руу чиглэгдэх болжээ. Ойрын 5 жилд хэрэгжүүлэх энэ хөтөлбөрт боловсон хүчин бэлтгэх, хөдөө орон нутгийн хөгжлийг дэмжих, байгаль орчиныг хамгаалах, дэд бүтцийг хөгжүүлэх 4 үндсэн чиглэлийг онцгойлж анхаарахыг заажээ.

Иргэдийн харилцаа. Өнөөдөр Японд Монголын 3,300 орчим иргэд амьдарч байгаагийн 2,000 орчим нь хараар амьдарч байгаа хүмүүс юм. Тэд мал маллах, ногоо тарих, ачаа буулгах, засвар үйлчилгээ хийх зэргээр амьдарч байна. Манайх 2005 онд Японы 12,272 иргэнд Монголд ирэх виз олгосон байна.

Соёл, боловсролын харилцаа. Японд 300 гаруй судлаачдыг нэгтгэсэн Монголч эрдэмтэдийн нийгэмлэг байдаг. 10 гаруй их сургуульд монгол хэл зааж, Монголын түүх, соёл, улс төр, эдийн засгийг судалж байна. Манай 30 орчим их, дээд сургуульд япон хэл зааж байна. Япон хэл суралцагсадын тоо 9,000-д хүрсэн мэдээ буй.

Манайх 1980 оноос Японд оюутнуудаа сургаж эхэлсэн. Одоо 806 оюутан, магистрант суралцаж байна. Эдгээрийн 240 нь Японы

засгийн газрын тэтгэлгээр, 566 нь хувийн зардлаар суралцаж байна. Эдгээр хүмүүсийг Японд явуулах бэлтгэлийг хангахад 3 жилийн өмнө Улаанбаатарт байгуулагдсан Монгол-Японы Хүний нөөцийн төв тустай ажил зохиож байна.

Монголын залуу үеийг боловсролтой болгох талаар Японы засгийн газар алсын хараатай, ухаалаг бодлого, цогц төлөвлөгөө хэрэгжүүлж байна.

Ерөнхий боловсролын шинэ сургуулиуд байгуулах, хуучин сургуулиудыг өргөтгөхөд их хөрөнгө зарцуулж байна. 1999 оноос хойш ерөнхий боловсролын 10-11 жилийн 3 сургууль шинээр барьж, 39 сургуулийн барилгыг өргөтгөснөөр 24,000 хүүхэд сургах шинэ хүчин чадал буй болгов. Ойрын жилд 2 сургууль барих, 6 сургуулийг өргөтгөх гэж байна. Ингээд нийт 50 сургууль барих, өргөтгөх юм.

Нийслэлийн 48-р дунд сургууль 4,300 сурагчтай учир 920 хүүхдийн багтаамжтай барилгад 3 ээлжээр нэг ангид 55-60 хүүхэд шахцалдан хичээллэж байв. 2005 онд Японы засгийн газар 720 хүүхдийн багтаамжтай өргөтгөлийн шинэ барилга барьж сургалтын тоног төхөөрөмжөөр тоноглож өгсөн тул одоо сурагчид 2 ээлжээр тавтай тохитой хичээллэдэг болов.

Монголын БСШУЯ, Японы Жайка байгууллагатай хамтран ерөнхий боловсролын сургуулиудыг компьютержуулж, интернетийн сүлжээнд холбох зардлыг “Сакура” төсөл гаргаж ажиллах боллоо. Одоогоор хөдөөгийн 63 сургуульд 458 компьютер бүхий кабинет байгуулж, интернетийн сүлжээнд холбоод байна. Энэ чухал ажил цаашдаа өрнөөсэй.

1990 оноос өнөөг хүртэл “Өвсний үндэс” гэдэг хөтөлбөрийн хүрээнд Японы засгийн газар Монгол Улсад нийт 12,8 сая ам.долларын өртөг бүхий 260 төсөл хэрэгжүүлжээ. Үүнээс 121 төсөл боловсролын салбарт хэрэгжиж 6,4 сая ам.доллар зарцуулсан байна. Эдгээрийн 102 нь ерөнхий боловсролын сургуулиудын хичээлийн болон дотуур байрыг засварлах, өргөтгөх, сургалтын материаллаг баазыг сайжруулахад чиглэгдсэн учир 28,035 хүүхэд тааламжтай байранд хичээллэх болжээ.

Миний бие 2003 оны намар Япон улсын элчин сайд ноён Т.Тодаг дагалдан Увс аймгаар аялаж билээ. Тариалан сум олон хүүхэдтэй нь яана. Сургуулийн дотуур байрны дээвэр, туурга нурж цоорсон, модон шал нь ялзарч цөмөрсөн учир тэр байранд суугаа хүүхдүүд бороо, салхи, шуурганд цохиулж арай хийж л амь мэнд тэсвэрлэж байдгийг элчин сайд сэтгэл зовинон танилцаад энэ байрыг засаж сайжруулахад туслана гэж амлахад зовлонд шаналж байсан олон хүүхэд багш их баярласан юм. Тэд нар ёстой л нүдэндээ баярын нулимстайгаар дуу

дуулцгааж элчин сайдыг халуун сэтгэлээр үдэж байж билээ. Элчин сайд амласандаа хүрч уг байрыг 43,318 ам.доллараар засуулж цэмцийсэн сайхан байр болгож өгсөн тул тэр сумын багш нар, эцэг эх, хүүхдүүд ёстой л нэг жаргалаа эдлэх болж наран мандах Япон орны зүг сөгдөн мөргөх болжээ.

Ер хоёр сая хагас хүн амтай улсад 152 сургууль барих, өргөтгөх, сэлбэн засварлах ийм аврага том төсөл хэрэгжсэн байна. Нэг улсад ийм олон төсөл ерөнхий боловсролын салбарт хэрэгжүүлсэн жишээ хаанаас олох юм бэ?

Японд Монголтой харилцдаг 70 орчим нийгэмлэг, манайд Японтой харилцдаг 30 гаруй нийгэмлэг бүртгэгдсэн байна. Монголын бөхчүүд 1992 оноос Японы мэргэжлийн сумогийн дэвжээнд амжилттай барилдаж хоёр орны харилцааны уур амьсгалыг улам найрсаг болгож байна. Японы сумод гадаадын 59 бөх барилдаж буйн 35 нь Монголын сумочид юм.

Монгол-Японы харилцааг цаашид хөгжүүлэх нь

Хоёр орны харилцааг XXI зуунд чиглүүлэн иж бүрэн түншлэлийн хэмжээнд хөгжүүлэх Японы 1996 оны саналыг Монголын тал сайшаан хүлээн авсан. Иж бүрэн түншлэл гэдэг маань харилцааг бүх салбарт хөгжүүлэх гэсэн үзэл бодол гэсэн ерөнхий ойлголт байдаг боловч үүнийг шинжлэх ухаан болгон томъёолон тодорхойлсон зүйл хоёр талдаа одоо болтол үгүй байна. Тиймээс эрдэмтэд мэргэдийн өргөн оролцоотойгоор томъёолох хэрэгтэй санагддаг.

Монгол Улсын Ардын Их Хурлаас 1994 онд баталсан гадаад бодлогын үзэл баримтлалд “Япон улсыг Ази дахь өөрийн гол түншийн нэг гэж үзэж найрсаг харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэхийг гадаад бодлогынхоо тэргүүн чиглэлийн нэг гэж үзнэ” гэсэн заалтыг бид удирдлага болгон ажиллаж байна. Монгол дахь улс төрийн аль ч хүчин энэ заалтыг дүүрэн зөвшөөрдөг.

1998 оны “Монгол Улс, Япон улсын найрамдал, хамтын ажиллагааны тухай” хамтарсан мэдэгдэл нь агуулга, ач холбогдлоороо найрамдал, хамтын ажиллагааны гэрээний түвшинд ойртсон тул энэ энэ мэдэгдлийг гэрээ болгох цаг болсон байх. Хоёр орны харилцааны өнөөгийн түвшин ийм гэрээтэй байх шаардлага тавьж байна гэж ойлгож болох юм.

Улс төрийн харилцааны түвшинг тасралтгүй өсгөж өндөр дээд хэмжээнд тогтмол барьж байхын тул ерөнхий сайд, ГЯЯ-ны сайд нарын айлчлал, хэлэлцээрийг 2 жил тутамд тогтмол хийж байх, 2006 онд манай шинэ Ерөнхий сайд М.Энхболд, Японы Ерөнхий сайд К.Коизуми нарыг харилцан айлчлуулах, Монгол Улсын ерөнхийлөгчийг 1997 онд

Японд албан ёсны айлчлалаар очуулж, Японы парламентын танхимын дарга нарын аль нэгийг, манай УИХ даргыг харилцан айлчлуулах. Япон-Австралийн харилцааны туршлагаар Монголын үйлдвэр-худалдаа, санхүү, боловсрол-шинжлэх ухаан, хөдөө аж ахуйн сайд нар, Япон улсын эдгээр яамдын сайд буюу орлогчийн хамтарсан хуралдааныг аль нэгэн улсдаа 2 жил тутам ээлжлэн хийж хамтын ажиллагаагаа төлөвлөдөг болох. Хоёр орны харилцаа, олон улсын асуудлаар Гадаад яамдын орлогч сайд нарын хэмжээнд зөвлөлдөх уулзалтыг жил бүр хийж байх.

Монгол-Японы харилцааны хөгжлийн өнөөгийн түвшин нь Япон улсын эзэн хааныг Монгол Улсад албан ёсны айлчлалаар ойрын жилд ирүүлэх яриа хэлэлцээг сэдэж эхлэх цаг болсон байх.

Оюу толгой, Таван толгойн том төсөлд оролцох, орон сууцны барилга барих гэх мэт том төслүүдэд Японы компаниудыг өрсөлдөх боломжоор хангах нь зүйтэй.

Японы фермерийн холбоотой харилцаагаа хурдан өсгөж хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах, аймаг сумдыг Японы муж, хотуудтай шууд холбоотой болгох нь маш хэрэгтэй.

Монголд ирдэг жуулчдын олонхи нь Япончууд байдаг атал Токио-Улаанбаатарын онгоцны тийз 2 талдаа 1,100-1,200 ам.доллар байдаг. Япончууд Парист 4 хоног, Бангкокт 5 хоног аялахад ер 500 ам.доллар төлдөг байна. Ийм байхад олон жуулчид Монголд аялахаас татгалзахад хүрдэг. Манай онгоцны тийзийг хямдруулж гарсан алдагдал-зөрүүг улс хариуцаж жуулчдын тоо нэмэгдсэнээс орох орлогоор нөхөх ухаалаг тооцоо хиймээр байна.

Манайх дунд, урт хугацааны бүхнийг хамарсан, хөгжлийн стратеги төлөвлөгөөтэй болмоор юм. Ийм төлөвлөгөөг, улс төрийн намууд, шинжлэх ухааны байгууллагуудтай хамтран боловсруулж, тэр нь парламентаар батлагдсан байвал аль ч нам засгийн эрхэнд гарсан ч биелүүлэх ёстой болно. Гадаад орнууд ийм төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар манайтай хамтран ажиллах нь ч хялбар болно.

Гагц Японд ч биш, ер нь гадаадад ажиллах дипломатчийг шилж, зөв хүн олох нь нарийн, төвөгтэй ажил. Тэр хүн дипломатын мэргэжил сайтай, ерөнхий мэдлэгийн хүрээ өргөн, суух орон, олон улсын байгууллага сайн судалсан, гадаадын 1-2 хэлний бичгийн ба ярианы чадвартай, ажлын дадлага туршлагатай буюу туршлагажиж байгаа, хамт олонтойгоо эв нэгдэлтэй ажиллаж чадах, хэрэг зөрчилд орооцолдохооргүй (өөрөө ба гэргий нь), үнэхээр эх оронч, эх орныхоо эрх ашгийг дээдлэж, зүүдлэж чаддаг, өөрийн орны эдийн засаг, санхүүгийн бэрхшээл, түүнд гадны ямар тусламж, хамтын ажиллагаа хэрэгтэй болохыг мэддэг байх хэрэгтэй. Нэг орон тоон дээр хэд хэдэн

хүнийг уралдаант шалгалтанд нээлттэй оруулж тодорсон хүнийг олон түмнээр хэлэлцүүлж болох юм. Тэр хэлэлцүүлэгт оролцох хүмүүс нь уг хүнийг үндэсгүй магтаж хөөргөх, эсвэл гүтгэж харлуулахгүй, гол нурууг нь зөв гаргахаар хүмүүс байх нь зүйтэй.

“Өвсний үндэс” хөтөлбөрт зарцуулагдаж буй хөрөнгө их биш атлаа Япон улсын ач тусыг ерийн олон түмэнд жинхэнэ амьдрал дээр нь харуулж байгаа нь чухал юм. Иймээс “Өвсний үндэс”-ээр хөдөөгийн сургуулиудад үзүүлж буй төслийн тоог нэмээсэй л гэж хүсмээр байна.

Японд суралцаж буй 806 оюутан, магистрантын 204 нь хүмүүнлэгийн ухаан, 231 нь нийгмийн ухаанд, техникийн мэргэжлээр ер 94 хүн суралцаж буйд дүгнэлт хийж инженер, техник, анагаах ухаан зэрэг мэргэжлээр сурах хүний тоог эрс нэмэгдүүлэх шаардлага байна. Засгийн газрын тэтгэлгээр суралцах оюутны тоог ч нэмэгдүүлмээр байна. Үүний тулд Монголд хийх хэлний бэлтгэлийг сайжруулах нь чухал.

Залуучуудын найрамдлын хөтөлбөр гэдэг нь 20-30 насны орон нутгийн залуу багш нарыг Японд урьж мэргэжлийн сургалтанд хамруулахын хамт хоёр орны ард түмний найрсаг харилцааг гүнзгийрүүлэх зорилготой ажээ. 2002 оноос эхлэн энэ төсөлд 70 багш хамрагдаж Японд мэргэжлээ дээшлүүлжээ. Энэ жил дунд сургуулийн байгалийн ухаан, математикийн 15 багш Япон улсад мэргэжил дээшлүүлээд ирэв. Манай ирээдүй болсон залуучууд Япон орны өндөр хөгжил, хүмүүсийн боловсон амьдрал, харилцааны соёлыг нүдээр үзэж олон багш сурган хүмүүжүүлэгчтэй танилцан холбоо тогтоож буй нь сайн хэрэг. Манай багш нар танилцсан хүмүүстэйгээ захидал харилцаатай байх төдийгүй тэднийг өөрийн сургууль, гэр бүлийн зочноор урьж айлчлуулах зэргээр холбоо харилцаагаа бататгаасай гэж хүсмээр байна.

2006, 2007 он бол Монгол, Японы амьдралд чухалд тооцогдох түүхэн үйл явдлын жилүүд юм. 2005 оны эцсээр ГХЯ-ны газрын дарга С.Хүрэлбаатар, Монгол-Японы Түншийн Холбоо нийгэмлэгийн ерөнхийлөгч Д.Содном нар Японд очиж парламентын гишүүд, Гадаад яамны албаныхан, төрийн бус байгууллагынхантай зөвлөлдөж 2006 оныг Япон дахь Монголын жил, 2007 оныг Монгол дахь Японы жил болгон өргөн ажил зохиохоор тохиролцсон боловч одоогоор нэг их өрнөөд байгаа ажил харагдахгүй байна. Иймээс уг ажлыг эрчимжүүлэх талаар хоёр Гадаад яам, найрамдал хамтын ажиллагааны байгууллагууд ажилламаар байна.

Египетийн цөлийг гүний усаар тэтгэж жимс, ногооны аж ахуй хөгжүүлж буйг би нүдээр үзсэн хүний хувьд Монголын говь цөлд Монгол-Японы хамтын ажиллагаа өрнөөсөй гэж хүсмээр байна. Египетээс

миний явуулсан үрээр Өмнөговьд 20 килограмм жинтэй тарвас, Дорноговьд Египетийн том сонгино амжилттай ургуулсан туршлага бий. Дорноговь, Өмнөговийн хөрсөн доорхи усыг ашиглан экологийн цэвэр жимс, ногооны Монгол-Японы хамтарсан том аж ахуйнууд байгуулан Монголын хэрэгцээг хангах төдийгүй Оросын Сибирийн том зах зээлд гаргаж болох юм. Энэ зорилгоор Японд газар түрээслүүлж ч болох юм.

Эцэст нь экологийн цэвэр жимснээс улс төрийн бохирдолд орж хохирч буй дипломат албаны тухай хэдэн үг хэлмээр санагдлаа. Япон улсыг манай гадаад харилцаанд чухал байр эзэлдэг гэж ярьсаар атлаа уг улсад ажиллах элчин сайдыг томилохгүй 10 сар болж байна. Хүн олдохгүйдээ бус, томчууд маань өөрийн талын хүнээ томилох хүсэлдээ баригдсанаас болсон хэрэг. Ерөнхий сайд хүн санал болгохгүй байна гэж ерөнхийлөгч хэлдэг. Улс орны эрх ашиг ингэж хохирч байхад Үндэсний Аюулгүйн Байдлын зөвлөлийн дарга хараад л сууж байх нь зөв гэж үү? Эрхэмүүд минь улс орныхоо эрх ашгийг тэргүүн ээлжинд бодоо ч дээ.